

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ТҮГЭЭМЭЛ ОЮУН СУРГУУЛИЙН 7 ДУГААР
АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар А

Хугацаа 60 минут

Нийт 20 оноо

УР УХААНААС ГЭРЭЛ ГЭГЭЭ ЦАЦАРНА

Уран бүтээлчид үе үеэрээ төрдөг нь жам биз. Ү. Ядамсүрэн нь зөвхөн зураач төдийгүй урлаг судлаач, сурган хүмүүжүүлэгч хүн байв.

Ядамсүрэн гуайн 1952 онд зурсан “Өвгөн хуурч” бүтээл нь Дели хотноо зохион байгуулсан олон улсын үзэсгэлэнгээс тэргүүн шагнал хүртсэн юм. Тэрээр хүний нүүр царай, ялангуяа гар хурууг маш сайхан зурдаг. Түүний бүтээсэн хөргүүд ямагт залуухан, цоглог, цэвэр цэмцгэр, ганган хээнцэр хүмүүс байдаг. “Өвгөн хуурч”-ийг ажиглаад байхад дүрийн царай төрх, нүд, зовхи, сахал, дээлийнх нь хээ, буржгар цагаан үсний ширхэг бүрийг маш нарийн дүрсэлсэн байдаг.

Ядамсүрэн гуай өөрөө юмыг их л няхуур боддог, ухаалаг сэтгэдэг, нямбай төдийгүй ганган хээнцэр, цэвэр цэмцгэр хүн байлаа. Өвөлдөө хүрэн өнгийн пүүсүү гадартай, халиу дотортой дээл өмсөн, минжин үсээр эмжсэн дэрвэгэр талтай, оройдоо том сампин зангидсан өндөр малгай духдуулан явдаг сан... Уран Жүрмэдийн хийсэн ногоон сарьсан хавчаартай, товгор хээ цохисон хүрэн өнгийн монгол гутал өмсөнө. Тэр ямагт янз бүрийн чамин хийцтэй үнэт чулуун хөөрөг бүхий даалин өвөртлөөд, таарсан хүмүүстэй тамхилдаг зантай. Хэдийгээр наян насыг зооглоод явж байгаа ч залуугийн ааг омог, хүч чадал нь биендээ багтаж ядан оволзож, урлахуйн их сэтгэл нь цээжин дотор нь дүрэлзэж яваа уран бүтээлч юм...

Түүний уран бүтээлийн баялаг амьдрал нэг ёсны нэвтэрхий толь юм.

Р.Бат-Очир

1. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг бичнэ үү. \2 оноо

.....
.....
.....

2. Дараах энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр болгон бичээд, ямар аргаар холбон бичсэнээ тайлбарлаарай. \2 оноо

Ааг омог, хүч чадал нь биендээ багтаж ядна. Их сэтгэл нь цээжин дотор нь дүрэлзэнэ.

ЗНӨ:.....

..

.....

...

Холбогдсон арга нь:

.....

3.Эхээс зэрэгцсэн нийлмэл үг 2-ыг олж бичээрэй. /2 оноо/

.....

...

4. Зөв харгалзуулаарай. /2 оноо/

- | | |
|--|------------|
| 1. Тэмдэг нэрийн бууруулсан зэрэг бүтээх дагавар | а. -уул2 |
| 2. Авиа дуурайх үг | б. тас няс |
| 3. Дүрс дуурайх үг | в. -втор4 |
| 4. Түгээл тооны нэр бүтээх дагавар | г. бут |

5. Нөхцөлийг залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлаарай. /2 оноо/

бодол-оос.....

Холбогдох дүрэм

.....

.....

...

6. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгон өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 40-50 үгэнд багтаан бичээрэй. /5 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. Үндэсний бичгээс кириллд хөрвүүлээрэй. /5 оноо/

ئىن ئا مەنتو مەن مەنتەس

مەنتەس .. ئىن ئىن

مەنتەس و مەنتەس ئىن ..

مەنتەس مەنتەس مەنتەس مەنتەس

ئىن مەنتەس مەنتەس ..

.....

.....

.....

.....

.....

.....

Хувилбар Б

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ТҮГЭЭМЭЛ ОЮУН СУРГУУЛИЙН 7 ДУГААР
АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

Хугацаа 60 минут

Нийт 20 оноо

Миний чулуу

...Хөлд орж тэнтэр тунтар алхсаар эцгийн гэрийн босгыг алхаж гарсан. «Уухай» гэж ижий минь урам оруулсан. Урамшаад би цааш алхсан. Үүдэн хоймор хэртэй яваад би хотныхоо чулуунд бүдэрч ойчсон. Уйлсан. «Өөрөө ойчсон хүүхэд уйлдаггүй юм» гэж гэрийн хойроос өвөө дуугарсан. «Өөрөө бос, миний хүү» гэж аав дэргэдээс хэлсэн. Хэн ч ирж босгохгүй болохоор нь хэсэг уйлж байгаад өөрөө боссон. Түүнээс хойш зөндөө бүдэрч ойчсон. Уйлаагүй. Бүдэрсэн чулуундаа өшрөөгүй. Амьтан хүн харахаас өмнө амжиж босож чаддаг болсон. Өвдсөндөө бус бусдаар өргүүлж босгуулах гэж уйлснаа хожим ухаарсан. Унаж босоход минь сургаж, ухаан, бие хоёрыг минь борогшуулсан Их Дэлгэрэхийн чулууг би хүндэлнэ.
Д.Батбаяр

1. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг бичнэ үү. \2 оноо

.....
.....
.....

2. Дараах энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр болгон бичээд, ямар аргаар холбон бичсэнээ тайлбарлаарай. \2 оноо

«Уухай» гэж ижий минь урам оруулсан. Би цааш алхсан.

ЗНӨ:.....

..

.....

.

Холбогдсон арга нь:

.....

3.Эхээс зэрэгцсэн нийлмэл үг 2-ыг олж бичээрэй. \2 оноо

.....

4. Зөв харгалзуулаарай. \2 оноо

- | | |
|--|--------------------|
| 1. Тэмдэг нэрийн бууруулсан зэрэг бүтээх дагавар | а. -аар4 |
| 2. Авиа дуурайх үг | б. сартага сартага |
| 3. Дүрс дуурайх үг | в. -дуу2 |
| 4. Түгээл тооны нэр бүтээх дагавар | г. хан ян |

5. Нөхцөлийг залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

харах+аас.....

Холбогдох дүрэм

.....
.....

6. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгон өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 40-50 үгэнд багтаан бичээрэй.

.....
.....
.....
.....
.....
.....
.....

7. Үндэсний бичгээс кириллд бичигт хөрвүүлээрэй.

ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ ᠮᠣᠩᠭᠣᠨ

.....
.....
.....
.....
.....
.....